



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/436

Мөрөн сум

Тендерт оролцогчдод тавих шалгуур
үзүүлэлт, гэрээний загвар маягт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 45.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Сангийн сайдын 2021 оны 124, 144, 145, 146 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад мөрдөх “Нээлттэй тендер шалгаруулалтаар ажил худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг нэгдүгээр, харьцуулалтын аргаар ажил худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг хоёрдугаар, Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бараа худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг гуравдугаар, харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг дөрөвдүгээр, зөвлөх үйлчилгээ сонгох тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг тавдугаар, зөвлөхийн бус үйлчилгээ сонгох тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлал, тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгт, гэрээний загвар маягт, тусгай нөхцөлд тусгах доод шалгуур шаардлагад нийцүүлэн захиалагчийн тендерийн баримт бичгийг боловсруулж, батлахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар, төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн захирал, удирдлагуудад тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН

d/zahiramj

671 0116 13